

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2025  
оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/039/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас:327734 Цахим хаяг: <a href="mailto:Nandinjargalg@audit.gov.mn">Nandinjargalg@audit.gov.mn</a></p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас:327734 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас:315558 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarda@audit.gov.mn">otgonbayarda@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Т.Гандолгор Утас:325093 Цахим хаяг: <a href="mailto:gandolgor.t@audit.gov.mn">gandolgor.t@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
**НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соблын төв өргөө Г корпус, 5 давхар,  
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200  
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13

№

773

танай

-ны №

-т

**НИЙСЛЭЛИЙН АВТОТЭЭВРИЙН  
ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН  
ТӨВ ОНӨААТҮГ-Н ДАРГА Э.НИНДЭВ  
ТАНАА**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 605.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох хууль журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага нь тайлант онд 4,424.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаандаа 4,376.4 сая төгрөгийг зарцуулж, 69.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Нийслэлд бүртгэлтэй автотээврийн хэрэгсэлтэй холбоотой нийт 13 төрлийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, үйлчилгээний төлбөрийг байгууллагын данс болон Гэрэгэ ХХК-ийн киоск машинаар дамжуулан хүлээн авсан байна.

C:\Users\nerengia\Desktop\Бичир хэргийг 2026\2025\word\yywan\_bichig\Ongnet\_2026.docx

1426052006

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 24/31 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын харьяалалтай тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох чиг үүрэг Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төв ОНӨААТҮГ-ыг байгуулж, байгууллагын дүрмийг баталсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудал**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 4 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 96.1 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		<b>5,091,779,747.31</b>
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		4,822,643,071.13
1.1.02	Дансны авлага		
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага		1,562,056.00
1.1.04	Бусад авлага		45,000,000.00
1.1.06	Бараа материал		222,574,620.18
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>5,091,779,747.31</b>
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.01	Үндсэн хөрөнгө		697,954,810.03
1.2.02	Биет бус хөрөнгө		107,895,300.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		<b>805,850,110.03</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>5,897,629,857.34</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		<b>1,948,492,500.84</b>
2.1.1.08	Урьдчилж орсон орлого		1,860,483,120.39
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		88,009,380.45
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>1,948,492,500.84</b>
<b>2.1.2.06</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		
2.3	Эздийн өмч		
2.3.01	Өмч: - төрийн		3,879,260,975.03
2.3.02	- хувийн		
2.3.03	- хувьцаат		
2.3.04	Халаасны хувьцаа		
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг		
<b>2.3.09</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>		
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг		69,876,381.47
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг		
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>		<b>3,949,137,356.50</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		<b>5,897,629,857.34</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

д/д	Үзүүлэлт	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>		<b>4,454,010,464.94</b>
2	Борлуулалтын өртөг		
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>		
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		

**Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
<b>8.1</b>	<b>Орлогын дүн</b>		<b>4,454,010,464.94</b>
9	Борлуулалт, маркетингийн зардал		2,470,053,535.80
10	Ерөнхий ба удирдлагын зардал		328,023,109.55
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		1,586,057,438.12
<b>12.1</b>	<b>Зардлын дүн</b>		<b>4,384,134,083.47</b>
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз, гарз		
<b>17</b>	<b>Бусад ашиг ( алдагдал)</b>		
17.1	Олз, гарзын дүн		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>		<b>69,876,381.47</b>
19	Орлогын татварын зардал		
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>69,876,381.47</b>
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>		<b>69,876,381.47</b>

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

д/д	Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг алдагдал	Нийт дүн
<b>8</b>	<b>2024 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
9	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
<b>10</b>	<b>Залруулсан үлдэгдэл</b>			
11	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	879,260,975.03		<b>879,260,975.03</b>
12	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
13	Тайлант үеийн цэвэр ашиг		69,876,381.47	69,876,381.47
14	Өмчид гарсан өөрчлөлт	3,000,000,000		3,000,000,000.00
15	Ногдол ашиг			
16	Гаргасан хувьцаат капитал			
<b>17</b>	<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>3,879,260,975.03</b>	<b>69,876,381.47</b>	<b>3,949,137,356.50</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

д/д	Үзүүлэлт	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		<b>9,199,013,112.22</b>
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>9,199,013,112.22</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		6,199,013,112.22
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		

**Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		3,000,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого		
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>4,376,370,041.09</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн		2,679,790,781.45
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		328,023,109.55
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		24,943,701.34
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		115,962,925.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн		33,990,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага		1,193,695,523.75
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>4,822,643,071.13</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>4,822,643,071.13</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,822,643,071.13

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

№	ҮЗҮҮЛЭЛТ	2025			
		ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ХЭМНЭЛТ ХЭТРЭЛТ	ГҮЙЦЭТ ГЭЛИЙН ХУВЬ
1	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>7,250,000,000.00</b>	<b>7,454,010,464.94</b>	<b>40,000,000.00</b>	103%
	Нийслэлийн төсвөөс татаас санхүүжилт	3,000,000,000.00	3,000,000,000.00	-	100%
	Үндсэн үйл ажиллагааны санхүүжилт	4,180,000,000.00	4,424,010,464.94		106%
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	70,000,000.00	30,000,000.00	40,000,000.00	43%
	<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>4,248,389,419.50</b>	<b>4,238,555,524.13</b>	<b>13,266,545.37</b>	100%
2	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	<b>2,506,655,484.00</b>	<b>2,470,053,535.80</b>	<b>36,601,948.20</b>	99%
	Үндсэн цалин	1,400,000,000.00	1,521,080,453.20	(121,080,453.2)	109%
	Нэмэгдэл	442,575,484.00	399,518,026.60	43,057,457.40	90%
	Унаа хоолны хөнгөлөлт	593,520,000.00	472,648,000.00	120,872,000.00	80%
	Урамшуулал	70,560,000.00	76,807,056.00	(6,247,056.00)	109%
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	<b>313,331,935.50</b>	<b>328,023,109.55</b>	<b>(14,691,174.05)</b>	105%
	Тэтгэврийн даатгал 8.5%	213,065,716.14	229,220,968.12	(16,155,251.98)	108%
	Тэтгэмжийн даатгал 1%	25,066,554.84	24,700,535.36	366,019.48	99%
	ҮОМШӨ-ний даатгал 0.5%	12,533,277.42	12,350,267.68	183,009.74	99%
	Ажилгүйдлийн даатгал 0.5%	12,533,277.42	12,350,267.68	183,009.74	99%
	Эрүүл мэндийн даатгал 2%	50,133,109.68	49,401,070.72	732,038.96	99%
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	<b>32,500,000.00</b>	-	<b>32,500,000.00</b>	0%
	Гэрэл, цахилгаан	8,000,000.00	-	8,000,000.00	0%
Түлш, халаалт	2,500,000.00	-	2,500,000.00	0%	

**Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Цэвэр, бохир ус	4,000,000.00	-	4,000,000.00	0%
Байрны түрээс	18,000,000.00	-	18,000,000.00	0%
Багаж, техник, хэрэгсэл	<b>877,002,000.00</b>	<b>738,288,408.00</b>	<b>138,713,592.00</b>	84%
Багаж, техник, хэрэгсэл /машин техник/	371,000,000.00	284,895,408.00	86,104,592.00	77%
Тавилга эд хогшил	200,202,000.00	178,791,000.00	21,411,000.00	89%
Маягт, гэрчилгээний үнэт цаас	305,800,000.00	274,602,000.00	31,198,000.00	90%
Хангамж, бараа материалын зардал	<b>181,600,000.00</b>	<b>325,011,533.80</b>	<b>(143,411,533.80)</b>	179%
Бичиг хэрэг	34,000,000.00	35,390,586.80	(1,390,586.80)	104%
Хангамжийн материал	95,600,000.00	234,680,947.00	(139,080,947.00)	245%
Тээвэр, шатахуун	32,400,000.00	33,990,000.00	(1,590,000.00)	105%
Хөдөлмөр хамгааллын зардал	19,600,000.00	20,950,000.00	(1,350,000.00)	107%
Мэдээлэл технологи холбооны зардал	<b>157,500,000.00</b>	<b>121,324,400.00</b>	<b>36,175,600.00</b>	77%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000,000.00	-	30,000,000.00	0%
Мэдээлэл технологийн үйлчилгээ, программын хөгжүүлэлт	127,500,000.00	121,324,400.00	6,175,600.00	95%
Бараа үйлчилгээний бусад зардал	<b>179,800,000.00</b>	<b>255,854,536.98</b>	<b>(72,621,886.98)</b>	142%
Урсгал засвар	92,600,000.00	132,721,000.00	(40,121,000.00)	143%
Хичээл үйлдвэрлэл, сургалтын зардал	5,300,000.00	8,732,650.00		165%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	-	5,000,000.00	0%
Даатгалын зардал	5,000,000.00	1,117,162.00	3,882,838.00	22%
Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	795,762.25	(295,762.25)	159%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	-	200,000.00	0%
Аудитын төлбөр				0%
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний шимтгэл	1,200,000.00	91,500.00	1,108,500.00	8%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	70,000,000.00	112,396,462.73	(42,396,462.73)	161%
Бусад зардал	-	-	-	0%
	<b>4,248,389,419.50</b>	<b>4,238,555,524.13</b>	<b>13,266,545.37</b>	100%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	4,248,389,419.50	4,238,555,524.13	13,266,545.37	100%
АШИГ, АЛДАГДАЛ	<b>1,610,580.50</b>	<b>215,454,940.81</b>	<b>26,733,454.63</b>	13377%
ТАТААС САНХҮҮЖИЛТ	3,000,000,000.00	3,000,000,000.00	-	100%
ТАТВАРЫН ЗАРДАЛ	161,058.05	21,545,494.08	2,673,345.46	13377%
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ АЛДАГДАЛ	1,449,522.45	193,909,446.73	24,060,109.17	13377%
АЖИЛЧДЫН ТОО	89	82	82	92%

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 605,394.2 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 67,040.7 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 58,100.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 480,253.5 мянган төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өглөө.

---

<sup>1</sup>Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**  
**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ажил гүйцэтгэх болон худалдах худалдан авах гэрээний төлбөрийг гүйцэтгэхдээ гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, үүргийн хэрэгжилтийг үндэслэн төлбөрийг шилжүүлээгүй.	1	91,845.0					1	91,845.0				
Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээг хийж, данс бүртгэлд тусгасан байна.	1	3,500.0					1	3,500.0				
Хөдөлмөр хамгааллын зардал гаргахдаа төлөвлөгөө тайланд үндэслэн гаргаагүй байна.	1	20,950.0					1	20,950.0				
Жилийн эцсийн тооллого хийхдээ өмч хамгаалах комисс байгуулж дүгнэлт гаргаагүй байна.	1						1					
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу компанийн захирал эрхээ бүрэн хэрэгжүүлэн үйл ажиллагааны журам, бүтэгдэхүүний борлуулалт, маркетингийн төлөвлөгөө, байгууллагын стратеги, урт хугацааны болон дунд хугацааны бизнес төлөвлөгөө зэрэг байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодлогын бичиг баримтуудыг боловсруулаагүй байна.	1						1					
Бараа материал орлогод аваагүй шууд зардалд бүртгэсэн байна.	1	33,750.0					1	33,750.0				

**Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Ажилчдыг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулсан зардал гаргахдаа төсвийг нийт дүнгээр нь төлөвлөөгүй, харьцуулсан үнийн судалгаагүй, шууд гэрээ байгуулаасан байна	1	40,450.0					1	40,450.0				
Нийт 1,860,483.1 мянган төгрөгийн УОО, 88,009.4 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, өр төлбөр үүсгэсэн байна.	1	88,009.4					1	88,009.4				
Жолооч нарын стомерийн заалтад үндэслэн шатахууны тооцоог тооцоо бодсон актаар баталгаажуулан гаргаагүй.	1	31,690.0					1	31,690.0				
Төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, хэмнэх зардлуудыг хэмнээгүй.	1	37,338.2					1	37,338.2				
Урсгал засвар хийх ажлын тоо хэмжээ, төсвийг нийт дүнгээр нь төлөвлөөгүй, харьцуулсан үнийн судалгаагүй, гэрээ байгуулаагүй, шууд худалдан авалт, ажил үйлчилгээ хийлгэсэн байна.	1	132,721.0					1	132,721.0				
Үйл ажиллагааны чиглэл зөрүүтэй байгууллагаар үйлчилгээ авсан	1	58,100.0			1	58,100.0						
Ажилчдын үнэмлэх хэвлүүлсэн, ажлын хувцас хийлгэсэн, бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан.	1	23,727.2	1	23,727.2								
Анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн.	1	39,930.0	1	39,930.0								
Зориулалт бус гүйлгээ хийж төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан	1	2,467.9	1	2,467.9								
НТЗ-ын Автобаазаас авто унахдаа нормоос хэтрүүлэн унасан байна.	1	915.6	1	915.6								
<b>Дүн</b>	<b>16</b>	<b>605,394.2</b>	<b>4</b>	<b>67,040.7</b>	<b>1</b>	<b>58,100.0</b>	<b>11</b>	<b>480,253.5</b>				

Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Санхүүгийн тайлангийн аудитын нийцлийн зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна.	1	196,497.8					1	196,497.8				
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ, гүйцэтгэлийн тайланг цахим систем (www.tender.gov.mn) болон шилэн дансны системд ил тод бүрэн мэдээлж, байршуулаагүй байна.	1						1					
Бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.	1	63,661.5					1					
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>260,159.3</b>					<b>3</b>	<b>260,159.3</b>				



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 582/Ав290344

Улаанбаатар хот

ММТ-2026/039/НА-СТН-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээ дэх үйл ажиллагааны чиглэлд тусгагдаагүй 58,100,000.00 (тавин найман сая нэг зуу) төгрөгийн үйлчилгээ авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.4-д "тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага хангасан байх", 37 дугаар зүйлийн 37.2.4-д "үйл ажиллагааны салбар, газар зүйн байрлалд үндэслэн захиалагчийг тодорхойлсон байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагад санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын дарга Э.Ниндэв, ерөнхий нягтлан бодогч М.Мэндбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Т.ГАНДОЛГОР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426091080



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 245/А0290344

Улаанбаатар хот

НТМ-2026/039/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатахуун зарцуулалтын нормоос хэтрүүлэн 915,600.00 (есөн зуун арван таван мянга зургаан зуу) төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ тогтоосон норм хэтрүүлэн зарцуулсан шатахууны 915,600.00 (есөн зуун арван таван мянган) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банк дахь НТАГ.хүү торгуулийн орлогын IBAN440090100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын дарга Э.Ниндэв, ерөнхий нягтлан бодогч М.Мэндбаяр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Т.ГАНДОЛГОР

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Корпус, 5 давхар

1426110<sup>8</sup>81



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 396/А0220344

Улаанбаатар хот

НТАГ-2026/039/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны дэмжих, нотлох баримтгүй 39,930,000.00 (гучин ёсөн сая ёсөн зуун гуч) төгрөгийн гүйлгээ хийж зардлаар бүртгэсэн байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтгүй бүртгэсэн зөрчлийн 39,930,000.00 (гучин ёсөн сая ёсөн зуун гуч) төгрөгийг Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын дарга Э.Ниндэв, ерөнхий нягтлан бодогч М.Мэндбаяр нараар нөхөн төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банк дахь НТАГ.хүү торгуулийн орлогын IBAN440090100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 30-ны дотор Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын дарга Э.Ниндэв, ерөнхий нягтлан бодогч М.Мэндбаяр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Т.ГАНДОЛГОР

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г.корпус, 5 давхар

1426110285



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 249/АД-2024

Улаанбаатар хот

НТАГ-2026/039/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглосон заалт зөрчиж 23,727,200.00 (хорин гурван сая долоон зуун хорин долоон мянга хоёр зуу) төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс, ажлын хувцас, ажлын үнэмлэх хэвлэж төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно", 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д "заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.3-д "хэвлэлийн захиалгын төлбөр", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглосон заалтыг зөрчин 23,727,200.00 (хорин гурван сая долоон зуун хорин долоон мянга хоёр зуу) төгрөгийг зарцуулсан тул ОНӨААТҮГ-ын дарга Э.Ниндэв, ерөнхий нягтлан бодогч М.Мэндбаяр нараар нөхөн төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банк дахь НТАГ.хүү торгуулийн орлогын IBAN440090100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын дарга Э.Ниндэв, ерөнхий нягтлан бодогч М.Мэндбаяр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Т.ГАНДОЛГОР

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Корпус, 5 давхар

1426110283



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 244/А0270344

Улаанбаатар хот

НТАГ-2026/039/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зориулалт бус 2,467,900.00 (хоёр сая дөрвөн зуун жаран долоон мянга есөн зуу) төгрөгийн гүйлгээ хийж төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Зориулалт бусаар зарцуулсан зөрчлийн 2,467,900.00 (хоёр сая дөрвөн зуун жаран долоон мянга есөн зуу) төгрөгийг Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын дарга Э.Ниндэв, ерөнхий нягтлан бодогч М.Мэндбаяр нараар нөхөн төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банк дахь НТАГ.хүү торгуулийн орлогын IBAN440090100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Корпус, 5 давхар

1428118897

2. Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ-ын дарга Э.Ниндэв, ерөнхий нягтлан бодогч М.Мэндбаяр нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Т.ГАНДОЛГОР

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар